

**БАЯНХОНГОР АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 07

Номгон

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Биелэлт
1	2	3	4	5
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;</p> <p>1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;</p>	<p>Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх</p> <p>-Дэмжиж хамтран ажилласан байх -Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх</p>	<p><b>Авлигатай тэмцэх газрын пэйж хуудас, АТГ-Олон нийтийн төв</b> албан ёсны хуудаснуудад байршуулсан мэдээллийг хэлтсийн фэйсбүүк хуудсаар 56 төрлийн мэдээг түгээж 6735 хандалт авч, 203 удаа түгээн ажилласан. АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 25 шторк, хэвлэн олшруулах 9 төрлийн материалууд, 99 групп, 53 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 44 төрлийн 115 зурган мэдээллийг байршуулан ажилласан.</p> <p align="right">Хэрэгжилт 100%</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Нэгдье” аяны хүрээнд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг өөрсдийн цахим хуудсанд “Нэгдье” постер зургийг байршуулан мөн аймгийн автобусны буудал болон аймгаас гарах, орох зам дагуу байрлах самбарт байршуулан, аймгийн нэгдсэн веб хуудас болох <a href="https://bayanhongor.gov.mn/">https://bayanhongor.gov.mn/</a>, болон “Нээлттэй засаг нэг Баянхонгор” page хуудсуудаар иргэд олон нийтэд хүргэн ажиллаж 6000 гаруй иргэний хандалтыг авсан. Мөн аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагааг явуулж байгаа 167 эрх зүйн хөтчөөр дамжуулан зохион байгуулсан авлигын эсрэг сургалтад хамрагдсан иргэд, төрийн албан хаагчдад шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 55 байгууллагын 18550 гаруй иргэд, төрийн албан хаагч, сурагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, захиалгат танхимын сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг</p>

1	2	3	4	5
				<p>дээшлүүлэн ажиллахын зэрэгцээ авлигын эсрэг аянд нэгдүүлэн ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		<p>1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;</p>	<p>-Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх</p>	<p>Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай “Нэг цонх”-ны үйлчилгээний төвийн зааланд “Шударга ёс хөгжил дэвшилд” нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажилласан. Тус 110 мэдээллийн самбарыг аймгийн хэмжээнд нийт 15 байгууллага тусгайлан захиалгаар хийлгэж авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийг байршуулан Шударга ёс хөгжил дэвшилд уриатайгаар иргэдэд сурталчлан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		<p>1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брөушур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>-Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх</p>	<p>Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий мэдээллийг өөрийн албан газарт байрлах 110 мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.</p> <p>Мөн тус самбарт иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж байгаа бөгөөд авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт бүхий 6 төрлийн гарын авлагыг 2500 иргэнд тарааж соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.</p> <p>Шүгэл үлээ, шударга бай, нэгдье гэсэн уриалга бүхий зурагт хуудсыг мөн 19 байгууллагын 65 төрийн албан хаагчдад тараан ажилласан.</p> <p>Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн постер зураг бүтээж Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн page хуудсанд байршуулан 900 гаруй иргэнээс хандалтыг авсан. Мөн Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас “Номгон ТВ” хамтран ажиллах гэрээнд энэ жилийг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан “Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдвээр нэвтрүүлэг хийж иргэд олон нийтэд түгээн ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

1	2	3	4	5
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх;	-Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	Авлигатай тэмцэх газарт аймгийн Засаг даргын албан бичгээр төрийн захиргааны эрх бүхий албан тушаалтнуудад сургалт хийлгэх захиалга өгсөн дагуу АТГ-аас төрийн захиргааны болон үйлчилгээний авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигыг ялж чадсан олон улсын туршлага сэдвээр 98 албан хаагчид сургалтыг зохион байгуулж хамтран ажилласан. <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		2.2. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Бэст хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэгч Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран Авлигатай тэмцэх газар хүсэлт тавьсны дагуу төрийн захиргааны албан хаагчдад “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж” сэдвийн хүрээнд сургалт мэдээллийг ашиг сонирхлын зөрчилд өртөх магадлалтай нийтийн албан тушаалтнуудыг сонгон 20 мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан. Мөн нийтийн албанд шинээр томилогдсон төрийн захиргааны болон үйлчилгээний 35 байгууллагын 186 албан хаагчдад “Авлигын ойлголт хор уршиг” сэдвээр сургалт зохион байгуулж мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлсэн. <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		2.3. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;	-Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх, -Хамрагдсан хүүхэд залуус, иргэд тоо	ЕБС-ын сургуулийн 2 сургуулийн 10-12 дугаар ангийн 110 сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нууцтай байх эрх” сэдвээр Аймгийн Прокурорын газрын зөрчлийн прокуророор сургалт хийлгэж эрх зүйн мэдлэг олгосон.  Төлөвлөгөөт сургалтын хүрээнд: Аймгийн 20 сум 55 байгууллагын давхардсан тоогоор 9226 төрийн албан хаагч, иргэд танхимын болон цахим сургалтыг зохион байгуулсан. Захиалгат сургалтын хүрээнд: Захиалгат сургалтын хүрээнд: Төрийн 43 байгууллага, 20 сумын төрийн захиргааны болон үйлчилгээний 9225 хүнд цахим болон танхимын сургалтыг зохион байгуулж мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлсэн  Ерөнхий боловсролын 7 сургуулийн 9-12 дугаар ангийн нийт 460 хүүхдийн ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн төлөвлөгөөг боловсруулж сургалт зохион байгуулсан.

1	2	3	4	5
				<p>Мөн аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга болон аймгийн Засаг даргаар сургагч багшийн төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар 02 өдөр 4 зорилт 15 арга хэмжээ төлөвлөн батлуулж хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
3	<p>Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах</p>	<p>3.1.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад олгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ</p>	<p>Иргэн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр Авлигатай тэмцэх газрын сургагч багш нар хамтран сургалт зохион байгуулж аймгийн хэмжээний сум байгууллагуудын 55 эрх зүйн хөтчийг авлигын талаарх сургалт, сурталчилгаа зохион байгуулах сургагч багшаар бэлтгэн гэрчилгээг нь гардуулан өгсөн.</p> <p>Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран жижиг дунд бизнэс эрхлэгч 32 иргэнд авлигын талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь" сэдвээр төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөл хөтөлбөр хариуцан ажилладаг байгууллагуудын мэргэжилтнүүдэд төрөөс жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн төсөл сонгон шалгаруулах, тус сангаас зээл олгохтой холбоотой хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргах явцад төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж, шударга ёсыг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид нийтийн эрх ашгийн төлөө ил тод нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 16 мэргэжилтнийг хамруулан тахимын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад оролцсон мэргэжилтнүүдэд 2 төрлийн боршур, 1 төрлийн хялбаршуулсан гарын авлагыг тарааж, эрх зүйн мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
4	<p>Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн</p>	<p>1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх</p>		<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах зорилгоор 2023 оны 02 дугаар сараас эхлэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн дүгнэлт хийсэн. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын</p>

1	2	3	4	5
	хяналтыг бий болгох			Хууль, эрх зүйн хэлтсээс авлигын талаарх тандалт судалгааг 2023 оны 05 дугаар сараас эхлэн 12 дугаар сарын 04-ний өдрийн хооронд цахим болон цаасан хэлбэрээр авахад 297 иргэн судалгаанд хамрагдсан. Судалгаанд үндэслэн 2024 оны төлөвлөгөөг холбогдох байгууллагатай хамтран гаргаж хэрэгжүүлэн ажиллахаар шийдвэрлэсэн.  Хэрэгжилт 100%
5	Авлигатай тэмцэх газраас газраас бүрэн эрхийнхээ газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	5.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, 5.2.Мөрдөгчийн мэдэгдэл, 5.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ;	-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Авлигатай тэмцэх газраас зөвлөмж ирүүлээгүй.Тус газраас 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 06/4398 албан бичгээр мөрдөгчийн мэдэгдэл ирж хариуг 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 4/755 албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн. 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 05/2860 Зөрчил арилгуулах албан бичгийн ирж хариуг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1а/148 албан бичгээр заасан хугацаанд тус тус хүргүүлэн ажилласан.  Хэрэгжилт 100%
6	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	6.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	-Уриа аянд нэгдсэн байдал  -Аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	Аймгийн хэмжээний нийт, сум байгууллагуудын дунд “Шударга удирдагч ил тод байгууллага” аяныг жилийн хугацаатай оролцсон байгууллагуудыг шалгаруулан шагнаж урамшуулсан. Тус аяны хүрээнд Авлигад үгүй гэж хэлээд өөрчлөө, Авлига үгүй бол төр амгалан Архи үгүй бол гэр бүл амгалан, авлигагүй нийгмийн төлөө, авлигагүй төрийн төлөө зэрэг уриалгуудыг дэвшүүлж 2500 гаруй иргэд, төрийн албан хаагч нэгдсэн. Олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, шударга ёсны зөв хандлага төлөвшүүлэх, авлигын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, түүний хор уршиг, үр дагаврыг ухуулан таниулах зорилгоор дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 1.650.000 төгрөгийн гэрээ байгуулан 1 сарын хугацаанд авлигын эсрэг радио мэдээ, зөвлөгөө мэдээлэл, бэлтгэн

1	2	3	4	5
		6.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;		MGL радиогоор 7 хоног бүрийн мягмар, пүрэв гаргуудад өдрийн 2 удаагийн давтамжтай нийт 88 удаа, лед дэлгэцээр 836 удаа, фэйсбүүк хуудсаар 35 удаагийн давтамжтай мэдээллийг тус тус иргэдэд хүргэн орон нутгийн телевиз болон аймгийн цахим, пэйж хуудсууд, лед дэлгэцээр дамжуулан нийт 75300 иргэнд хүргэж ажилласан.  Хэрэгжилт 100%
		6.3. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг нийт албан хаагчдадаа танилцуулах	Хэлтсийн хэмжээнд 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулан дүгнүүлсэн.  Хэрэгжилт 100%
		6.4.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	Үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах	Ажил орлоготой иргэн, Архигүй эрүүл өрх, Авлигагүй шударга төрийн төлөө хамтран ажиллах зорилгоор 10 зүйл бүхий үүргийг хүлээлгэн 20 сумын Засаг дарга, 23 агентлагийн дарга 10 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нартай хоёрт талын гарын үсэг бүхий БАТЛАМЖИЙГ гардуулан өгч баталгааг гаргуулан ажилласан.  Хэрэгжилт 100%
		6.5.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	Нэмэлт төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байх	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, удирдах албан тушаалтны авлигатай тэмцэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээний сум байгууллагуудын дунд “Шударга удирдагч ил тод байгууллага” аяныг 3 дахь жилдээ зарлан удирдамжийг аймгийн Засаг даргаар батламжлуулан ажилласан. Аяны хүрээнд: Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 25 төрлийн зурган 56 төрлийн постер мэдээллүүдийг байршуулан ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Нэгдье” аяны хүрээнд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг өөрсдийн цахим хуудсанд “Нэгдье” постер зургийг байршуулан мөн аймгийн

1	2	3	4	5
				<p>автобусны буудал болон аймаг орох зам дагуу байрлах самбарт авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн постер зургийг байршуулан аймгийн нэгдсэн веб хуудас болох <a href="https://bayanhongor.gov.mn/">https://bayanhongor.gov.mn/</a>, болон “Нээлттэй засаг-нэг Баянхонгор” page- хуудасуудаар иргэд олон нийтэд хүргэн 5000 иргэний хандалтыг авсан.</p> <p>-Монголын хүүхдийн спортын зуны VII наадам Баянхонгор аймагт зохион байгуулж байгаатай холбогдуулан нийт тэмцээнд оролцож буй 5000 гаруй тамирчдын дунд <b>“Ирээдүйнхээ төлөө нэгдье”</b>, <b>“Зөв хүмүүжил, Зөв дадал”</b> соён гэгээрүүлэх өдөрлөгийг 10 өдрийн турш зохион байгуулж авлигын эсрэг нэгдүүлсэн.</p> <p>-Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 64 зурган мэдээллийг байршуулан ажилласан.</p> <p>Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хууль, эрх зүйн болон хүний эрхийн талаарх ойлголт, мэдээлэл өгөх, ялгаварлан гадуурхалт ба дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн ухамсрыг нь дээшлүүлэх зорилгоор “Ялгаварлан гадуурхалт ба дээрэлхэлд болон эрх зүйн мэдлэг олгох” танхимын сургалтыг зохион байгуулан аймгийн төвийн 6 сургуулийн 460 сурагчийг хамруулан мэдлэг ойлголтыг бататгах 3 төрлийн 1380 ширхэг гарын авлага материал тарааж хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч авлигын эсрэг нэгдүүлсэн. Ингэснээр сурагчдын эрх зүйн мэдлэг ойлголт нэмэгдэж аливаа гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байж хэрхэн урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн мэдээлэлтэй болсон.</p> <p>Хүүхдийн сэтгэн бодох, урлан бүтээх чадварыг хөгжүүлэх, өөрийн дотоод ертөнцөө нээн, илэрхийлэх ур чадварт сургах, гэр бүлийн аз жаргалыг үгээр болон, гараар урлах ур чадварыг хөгжүүлэх зорилгоор 3-9 насны хүүхдүүдийн дунд <b>“Ээждээ хэлэх миний сэтгэгдэл”</b> сэдэвт зохион бичлэгийн уралдаан, 10-14 насны хүүхдүүдийн дунд <b>“Авлига миний нүдээр”</b> гар зургийн бүтээл, 15-18 насны хүүхдүүдийн дунд <b>“Авлига”</b> гэж юу вэ? сэдвээр эссэ бичих</p>

1	2	3	4	5
				<p>уралдааныг зохион байгуулж ирүүлсэн бүтээл тус бүрийг мөнгөн шагналаар урамшуулан ажилласан.</p> <p>Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн 56 эцэг эхэд чиглэсэн албан үүргээ гүйцэтгэж байгаа ажилтнуудад бэлэг шан харамж өгөх шаардлагагүй сэдвээр мэдээлэл хийж нийт эцэг эхийн 82.4%-д нь танилцуулсан.</p> <p>Төрийн аудитын газраас ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчид, Политехникийн оюутнуудын дунд “Авлигагүй ирээдүй” гар зургийн уралдааныг зохион байгуулж Бууцагаан сумын 2 сурагч 1,3 дугаар байр, Эрдэнэмандал ахлах сургуулийн сурагч 2 дугаар байрт тус тус шалгарсныг шагнаж урамшуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас жил бүр зохион байгуулдаг Хүүхдийн шударга байдал”-ын 2023 оны судалгааг удирдамжийн дагуу зохион байгуулж 79 сурагч, 15 багш, 15 эцэг эхийн төлөөллийг оролцуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		<p>6.5.1 И-Монголиа, Аймаг, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээнээс бусад төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах</p>	<p>Төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажилласан байх</p>	<p>Төрийн үйлчилгээг цахимжуулах, хүн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэгийг байгуулан Баянхонгор аймгийн төв болон 6 суманд Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” цэгийг нээсэн. Ингэснээрээ төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх боломж бүрдсэн. Мөн орон нутгийн онцлогтой 21 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимд шилжүүлээд байна. Тус ажлын үр дүнд төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх нөхцөл боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		<p>6.5.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хугацаа хэтрүүлэхгүй байх, бодитой шийдвэрлэж хугацаанд нь зохих хариу өгөх ажлыг сайжруулах ажил зохион</p>	<p>Өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж хариу өгөх</p>	<p>Төрөөс иргэдэд олгодог бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үнэ, төлбөргүй хүргэх, төрийн байгууллагатай холбоотой гомдол саналыг цахим хэлбэрээр хүлээн авч иргэдэд хүргэх үйлчилгээг ойртуулах зорилгоор аймгийн төрийн байгууллагуудын дунд e-office системийг нэвтрүүлж тухайн байгууллагатай холбоотой өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх нөхцөл бүрдсэн.</p>

1	2	3	4	5
		байгуулах. /Албан хаагчдын ёс зүйн зөрчил, дутагдал хамаарах/		Энэ оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар аймгийн нийт төрийн байгууллагуудаар 1285 хүн үйлчилгээ авсан.. Хэрэгжилт 100%
		6.5.3 Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах. /Жишээ нь: Ажлын хэсэг байгуулсан, хэн нэгэн албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилт үр дүнг тооцох, тушаал шийдвэр гаргахдаа үндэслэх хэсэгт Хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгахад чиглэсэн/	Удирдлагаас гарч байгаа шийдвэрийн үндэслэлийг зөв гаргахад чиглэсэн арга зүйн зөвлөгөө өгөх	Шинээр нэвтрүүлж буй "Eoffice" системээр Аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал зэргийг тухай бүр гаргахаас нь өмнө хуулийн үндэслэлийг хянаж баталгаажуулдаг болсон. Сумдын Засаг даргын Захирамжийг эх хувиар нь улирал бүрээр ирүүлснийг хянаж зөвлөмж хүргүүлэн ажилласан. Жилийн эцсийн байдлаар 20 сумын 951 захирамжийг эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөмж хүргүүлэн зөрчлийг арилгуулан ажилласан. Мөн авлигатай тэмцэх газрын сургагч багш нарын хамтран сургагч багшаар бэлтгэсэн аймгийн сум байгууллагуудын эрх зүйн хөтөч нарт зориулан удирдлагаас гарч буй шийдвэрүүдийн эрх зүйн үндэслэлийг хянахад анхаарах талаар зүйлүүдийн талаар чиглэл өгч тушаалын төслүүдийг бэлтгэн өгсөн. Хэрэгжилт 100%
		6.5.4 Худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах. Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах, тогтмол оруулахаас зайлсхийх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн ажил зохион байгуулах/	Үнэлгээний хорооны гишүүдийн тоог нэмэгдүүлэх тэднийг чадавхжуулах чиглэлээр арга хэмжээ авах	Үнэлгээний хороо тайлант хугацаанд 47 үнэлгээний хороо байгуулагдан давхардсан тоогоор 91 шийдвэр гаргасан бөгөөд шийдвэр бүрийг цахим хуудсанд байршуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүн тус бүрт иргэний төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулан ажиллаж. Төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх "АЗ" сертификат олгох сургалтыг "Худалдан авах ажиллагааны сургалт судалгааны төв" ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтад аймгийн бүх сумдаас төрийн алба, төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нийт 116 хүн хамрагдснаас 65% буюу 76 хүн шалгалтанд тэнцэж, шинээр төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сертификат авсан. Дэлхийн банкны дэмжлэгээр Сангийн яамны Хууль эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс, Тогтвортой амьжиргаа -3 төсөлтэй хамтран "Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан" бэлтгэх сургалтыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нийт

1	2	3	4	5
				<p>110 хүн хамрагдаж шинээр төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сертификат авсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
7	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</p>	<p>7.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/</p>	<p>-Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх</p>	<p>Төрийн үйлчилгээг цахимжуулах, хүн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг байгуулан Баянхонгор аймгийн төв болон 6 суманд Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийг нээсэн. Ингэснээрээ төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх боломж бүрдсэн. Мөн орон нутгийн онцлогтой 21 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимд шилжүүлээд байна.</p> <p>Өргөдөл гомдол хүлээн авах, цаасан суурьтай баримтыг халах, сумдын засаг даргын захирамжийг тухай бүр хянаж хуулийн үндэслэлийг хянаж саналаа өгөх төрийн үйл ажиллагааг түргэн шуурхай ил тод нээлттэй явуулах зорилгоор e-office системийг нэвтрүүлснээр 1285 хүн, хуулийн этгээд үйлчилгээ авсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		<p>7.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан байх</p>	<p>Аймгийн гэмт хэргэг, зөрчлөөс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтэс Прокурорын газартай хамтран аймгийн хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг байгуулсан. Тус зөвлөгөөнөөр Авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авч, авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах талаар тус зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжид тусган хэрэгжилтийг ханган ажилласан. Ингэснээр аймгийн хэмжээн дэх авлигын гэмт хэргэ өмнөх онд 15 бүртгэгдэж байсан бол энэ онд 14 болж 1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
		<p>7.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг</p>	<p>Судалгааг авч нэгтгэн дүгнэх</p>	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах зорилгоор 2023 оны 02 дугаар сараас эхлэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний</p>

1	2	3	4	5
		<p>тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.</p>		<p>төвөөр үйлчлүүлж буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн дүгнэлт хийсэн.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс авлигын талаарх тандалт судалгааг 2023 оны 05 дугаар сараас эхлэн 12 дугаар сарын 04-ний өдрийн хооронд цахим болон цаасан хэлбэрээр авахад 297 иргэн судалгаанд хамрагдсан.</p> <p>Судалгаанд оролцогчдын 46.2 хувь нь 20-45 насны иргэд оролцсон бөгөөд ажил эрхлэлтийн байдлаар ангилбал төрийн албан хаагч 39,8 хувийг, хувийн хэвшлийнхэн 38,4 хувь хамрагдсан.</p> <p>Судалгааны дүнгээс үзэхэд нийгэмд авлига дунд зэрэг 28.3 хувь нь харилсан байна. Харин аль түвшний албан тушаалтан авлигад хамгийн их өртөх магадлалтай вэ гэсэн асуултад удирдах албан тушаалтнууд гэж 73.1 хувь, гүйцэтгэх албан тушаалтан гэж 13.3 хувь нь, бүгд гэж 12.2 хувь нь хариулсан.</p> <p>Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалтуудыг зөрчиж албан үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас бэлэг, шан харамж авах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх, албаны мэдээлэл ашиглахтай холбогдсон хориглолт хязгаарлалтыг зөрчих, давхар ажил эрхлэхтэй холбогдсон хориглолт хязгаарлалтыг зөрчих тохиолдлууд ихэвчлэн гарч байгаа бөгөөд эдгээр нь Шүүх, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газрын, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зэрэг төрийн захиргааны байгууллагуудад ихэвчлэн илэрдэг гэж судалгаанд оролцогчдын 49 хувь нь хариулсан.</p> <p>Дээрх судалгаанд үндэслэн 2024 оны төлөвлөгөөг холбогдох байгууллагатай хамтран гаргаж хэрэгжүүлэн ажиллахаар шийдвэрлэсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

1	2	3	4	5
8	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	<p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;          -Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4          - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах</p>	-Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	<p>Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, агентлаг, байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын цахим систем хариуцсан ажилтан, албан хаагчид /мэргэжилтэн/, зэрэг 90 гаруй алба хаагчдад “Шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилт”, “Монгол улсын Засгийн газрын 2023 оны “Авлигын эсрэг болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол”, “Meduuleg.iaac.mn цахим систем ашиглалт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлагналт” Албан ёсны цахим системийн ашиглалт, Төрийн үйлчилгээний цахим системийн ашиглалтын үр дүн зэрэг сэдвүүдээр Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсүүд чиг үүргийн хүрээнд сургалт, мэдээлэл зохион байгуулсан.</p> <p><b>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-иар</b> төлөвлөгөөт сургалтын хүрээнд 20 байгууллагын 1000 гаруй алба хаагчид зохион байгуулсан. Мөн цахим хуудасны ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр жилийн хугацаатай аян зарлаж шалгуур үзүүлэлтэд тусган оруулж хэрэгжилтийг хангуулсан. Төрийн байгууллага албан тушаалтнаас иргэдийн мэдэх эрхийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн цахим хуудсанд хөгжүүлэлт хийх сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудад Монгол Улсын Засгийн газраас зарласан 5Ш ажиллагаа болон цахим хуудасны хөгжүүлэлт хийхэд анхаарах асуудал сэдвээр сургалт мэдээлэл хийж ил тод байх бүх шалгуур үзүүлэлтүүдийг цахимаар болон хялбаршуулсан гарын авлага хэлбэрээр тэдний албан хэрэгцээнд тарааж өгсөн.</p> <p>Эдгээр ажлуудыг зохион байгуулсны үр дүнд шил ажиллагааны хүрээн дэх <a href="https://shilen.gov.mn">https://shilen.gov.mn</a> цахим системийн үнэлгээ 2022 онд 67,01 хувьтай байсан бол 2023 оны 12 дугаар сарын эхний хагаст 91,01 хувь болж 24 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>

1	2	3	4	5
		-Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг үнэн зөв тайлагнан хагас жилд 06 дугаар сарын 10/ жилийн эцэст 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх	Тайланг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хагас жилд 06 дугаар сарын 10/ жилийн эцэст 12 дугаар сарын 10-ны дотор Авлигатай тэмцэх газарт цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэн, цахим системд шивж баталгаажуулан хэрэгжилт үр дүнг тооцуулан ажилласан.  Хэрэгжилт 100%

ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.САРАНГАРАВ

НЭГТГЭСЭН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЛХАМДУЛАМ

